

## VI АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР

Хувилбар А.

Хугацаа 40 мин

Нэгдүгээр хэсэг:

1.  $a = \frac{5}{16} \div 6$      $b = \frac{5}{16} \div 0.6$      $c = \frac{5}{16} \div 1$     илэрхийллийг өсөх эрэмбээр байрлуул.  
 A.  $a < b < c$     B.  $c < a < b$     C.  $a < c < b$     D.  $c < b < a$ .

2.  $72x - 90y$     ерөнхий үржигдэхүүн хаалтнаас гарга /2 оноо /

A.  $2(36x - 45y)$     B.  $18(4x - 5y)$     C.  $6(12x - 15y)$     D.  $3(24x - 30y)$

3. Ангийн зургаан сурагчийн өндөр өгөгдөв. 1,4м ; 1,6м ; 1,6м ; 1,9м ; 1,2м ; 1,3м. Сурагчдын өндрийн моод, далайц, арифметик дунжийг олоорой.

4.

Сонгох хэсэг дугуйлна уу?	Моод	Далайц	Арифметик дундаж
A	1,2 м	0,7 м	1,4 м
B	1,6 м	0,6 м	1,5 м
C	1,9 м	0,3 м	1,6 м
D	1,6 м	0,7 м	1,5 м

5. Улаанбаатараас Сүүл хүртэл 3 цаг 5 минут нисдэг. Хэрэв Улаанбаатарын цагаар 23 цаг 40 минутад Сүүл рүү ниссэн бол Сүүлд орон нутгийн цагаар хэдэн цагт буусан бэ?

A. 3 цаг 40 минут    B. 15 цаг    C. 3 цаг 45 минут    D. 2 цаг 45 минут

6. Хоёр цагийн  $\frac{6}{20}$  хэсэг нь хэдэн минут вэ?

A. 18 мин    B. 5 мин    C. 36 мин    D. 15 мин

7. Функцийн дүрмийг ол.

x	-2	1	4
y	-4	2	8

A.  $y = -3x$     B.  $y = 3x$     C.  $y = 3x + 1$     D.  $y = 3x - 1$

8. Параллелограммын хоёр тал нь 3:4 харьцаатай ба периметр нь 28 см бол талуудыг ол. /2оноо/

A. 3см, 4см    B. 6см, 8см    C. 9см, 12см    D. 12см, 16см

**Хоёрдугаар хэсэг:**

1. Үйлдлийг гүйцэтгэ. (4 оноо)     $6\frac{4}{9} \cdot 1\frac{7}{29} + \left(9\frac{1}{6} - 3\frac{3}{4}\right) : 4\frac{1}{6} =$

2. Нэг айлын халуун усны тоолуур 3 дугаар сард 18949 м.куб гэсэн заалттай байв. Дараагийн сард 18954 м.куб гэсэн заалт гарсан байв.

а. Нэг сарын турш энэ айл хэдэн литр ус хэрэглэсэн бэ?

б. 1м.куб усны үнэ 1250 төгрөг ба хэрэглэсэн бол усны үнэнд хэдэн төгрөг төлөх вэ?

3. Таамгаар гурван оронтой тоо сонгоход яг 1 цифр нь 0 байх магадлалыг ол.

### Хувилбар Б.

1.  $a = (-3)^2 + \sqrt{25}$   $b = \sqrt{121} - 0.5^2$   $c = \sqrt{4^2} + 2^3$  илэрхийллийг өсөх эрэмбээр байрлуул.

A.  $a < b < c$  B.  $c < a < b$  C.  $a < c < b$  D.  $c < b < a$ .

2.  $96x - 36y$  ерөнхий үржигдэхүүн хаалтнаас гарга

A.  $3(32x - 12y)$  B.  $4(24x - 9y)$  C.  $6(16x - 6y)$  D.  $12(8x - 3y)$

3. Сурагчдын шалгалтын дүн өгөгдөв. 69, 57, 72, 74, 76, 80, 68, 72

а) Сурагчдын медианыг ол.

б) Далайцыг ол.

с) Арифметик дундажийг ол.

Сонгох хэсэг дугуйлна уу?	Медиан	Далайц	Арифметик дундаж
A	69	11	74
B	74	23	71
C	71	12	72
D	72	4	68

4. Улаанбаатараас Лондон хүртэл 6 цаг 5 минут нисдэг. Хэрэв Улаанбаатарын цагаар 18 цаг 30 минутад Лондон руу ниссэн бол Лондонд орон нутгийн цагаар хэдэн цагт буусан бэ?

A. 16 цаг 35 минут B. 20 цаг C. 17 цаг 35 минут D. 8 цаг 35 минут

5. Функцийн дүрмийг ол.

x	-2	1	4
y	-4	2	8

A.  $y = -2x$  B.  $y = 2x + 1$  C.  $y = 2x - 1$  D.  $y = 2x$

6. 9 км-ийн  $\frac{3}{5}$  нь хэдэн метр вэ?

A. 54 м B. 540м C. зөв хариулт байхгүй D. 5400 м

7. Гурвалжны хоёр тал нь 7 см, 16 см бол 3 дахь талын авч болох хамгийн их бүхэл тоон утгыг ол. /2 оноо/

A. 16см B. 17см C. 22см D. 23см

### Хоёрдугаар хэсэг

1. Үйлдлийг гүйцэтгэ. (4 оноо)  $5\frac{4}{7} \times 2\frac{9}{13} - 1\frac{2}{3} \div (4\frac{2}{9} - 2\frac{5}{6}) =$

2. Хавтан 150 дм.кв хэмжээтэй ба 1 м.кв хавтан 6500 төгрөгийн үнэтэй бол

а. 18 м.кв ханыг бүрэхэд хэдэг төгрөг хэрэгтэй вэ?

б. 18 м.кв ханыг бүрэхэд хичнээн хавтан орох вэ? /3 оноо/

3. Таамгаар гурван оронтой тоо сонгоход яг 2 цифр нь ижил байх магадлалыг ол. /3 оноо/

